



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2013 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах
техникийн нөхцөл олгох журам батлах тухай

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг холбогдох хууль дүрмийн дагуу зүй зохистой хангах зорилгоор цахилгаан эрчим хүчний системүүд болон төвлөрсөн дулаан хангамжийн системийн дамжуулах, түгээх шугамын техникийн боломжит хүчин чадалд нийцүүлэн шинээр баригдаж байгаа барилга байгууламжийг шугам сүлжээнд холбох үйл ажиллагааг зохицуулах “Цахилгааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Журам батлагдсантай холбогдуулан цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох комисс /ажлын хэсэг/-ын бүрэлдхүүнийг томилж, ажиллуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Дэлгэрцогт/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Л.Батсайхан/-д, батлагдсан журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга /П.Товуудорж/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



М.СОНОМПИЛ